



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 1/42

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлж, төлөвлөх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батчулуун (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ц.Мягмарсүрэн (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Ц.Баатарсүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн)

А.Норпил (Газрын даамал)

Г.Лхагвабуд (Хотын захирагчийн албаны ерөнхий менежер)

Э.Очир-Эрдэнэ (Архитектор)

Э.Базардаарий (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Н.Нямдаваа (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2.Иргэдээс ирүүлсэн саналыг холбогдох журмын дагуу нэгтгэн эрэмбэлж, зөвлөмж, дүгнэлт гаргаж танилцуулахыг ажлын хэсэг (Д.Батчулуун)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ



401100093